



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 5/49

Ховд

Э.Уртнасанг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалтууд, Үенч сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 2/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 05/14002 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Энхээгийн Уртнасанг 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн Үенч сумын Засаг даргаар томилсугай.

2. Э.Уртнасанг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох” 11 дүгээр хавсралтын дагуу 1015984 төгрөг /Нэг сая арван таван мянга есөн зуун наян дөрвөн/-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр олгохыг Үенч сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /П.Булганбат/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Э.Уртнасанд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax B/49 Ch  
02 4-80